



Семинарын суралцахуйн үнэлгээний шалгалт

Семинарын суралцахуйн үнэлгээний шалгалт

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс
хэвлэв
Юта муж, Солт Лэйк хот

Санал хүсэлт, залруулгыг талархан хүлээн авна. Та саналаа дараах хаягаар илгээнэ үү.

Seminaries and Institutes of Religion Curriculum Services

50 East North Temple Street

Salt Lake City, Utah 84150-0008 USA

Э-мэйл хаяг: ces-manuals@ldschurch.org

Та овог нэр, хаяг, гадас, тойргоо бичнэ үү. Суралцахуйн үнэлгээний шалгалтын эсвэл судлах удирдамжийн нэрийг тавихаа мартуузай. Дараа нь санал хүсэлтээ бичнэ үү.

© 2016 by Intellectual Reserve, Inc.

Бүх эрх хамгаалагдсан.

Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв

1-р хувилбар, 12/16

Англи эхийн зөвшөөрөл: 8/16

Орчуулгын зөвшөөрөл: 8/16

Seminary Learning Assessments-ын орчуулга

Mongolian

PD60002566 363

Агуулга

Оршил	v
Суралцахуйн үнэлгээний шалгалтын тойм	vii
Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан зохицуулалт хийх нь	ix
Судлах удирдамж	1
Сургаал ба Гэрээ 1–75 ба Иосеф Смит—Түүх	3
Сургаал ба Гэрээ 76—Албан Тунхаг 2	5
Хуучин Гэрээ: Эхлэл—Рут	7
Хуучин Гэрээ: 1 Самуел—Малахи	9
Шинэ Гэрээ: Матай—Иохан	11
Шинэ Гэрээ: Үйлс–Илчлэлт	14
Мормоны Ном: 1 Нифай 1—Алма 16	17
Мормоны Ном: Алма 17–Моронай 10	20

Удиртгал

Суралцахуйн үнэлгээний шалгалтын тойм

Суралцахуйн үнэлгээний шалгалт нь суралцагчдад чухал сургаал, зарчмуудыг ойлгох, тайлбарлах болон амьдралдаа хэрэгжүүлж, гэрчлэхэд тусална. Кредит авахын тулд тухайн курсын суралцахуйн үнэлгээний шалгалтыг амжилттай өгөх шаардлагатай.



Та багш эсвэл зохицуулагчийн хувьд “Best Practices for Learning Assessments” (8:30) видео бичлэгийг үзсэнээр суралцагчдадаа суралцахуйн үнэлгээний шалгалтыг амжилттай өгөхөд бэлдэхэд нь тусалж болно. Видео бичлэгийн санал болгосноор “Best Practices for Learning Assessments” материал дээрх хэсгүүдтэй танилцаад, хий.

Түүнчлэн та суралцагчдадаа хичээлийн явцад гол сургаал, зарчмуудыг тууштай зааж, онцолж, дахин авч үзэх арга замаар суралцахуйн үнэлгээний шалгалтыг амжилттай өгөхөд нь тусалж чадна. Судлах удирдамжууд нь багш, суралцагчдад тухайн курсийн зарим гол сургаал, зарчмыг олж тогтооход туслах зорилготой.

Суралцахуйн үнэлгээний шалгалтын программ нь шалгалтыг удирдан явуулж, хариултыг хурдан шуурхай цуглуулж авахад тань тусална. Та шалгалтыг хоёр арга замаар авах боломжтой.

- **Онлайн.** Энэ арга зам нь суралцагчдад суралцахуйн үнэлгээний шалгалтаа компьютер эсвэл гар утсаа ашиглан өгөх боломж олгоно. Шалгалтыг автоматаар дүгнэх ба суралцагчид аль асуултад алдсанаа харах боломжтой тайланг хүлээн авдаг.
- **Хэвлэмэл.** Энэ арга зам нь суралцахуйн үнэлгээний шалгалтыг өгөхдөө үзэг, цаас ашиглах боломжийг олгоно. Шалгалтын буддаг хуудас нь суралцагч бүрд зориулсан тусгай кодтой байна. Та шалгалтын буддаг хуудсуудыг уншуулахад тэдгээр нь автоматаар дүгнэгдэнэ.

Программ хангамжийн талаарх сургалт дараах хэлээр байгаа. Үүнд:

хятад

англи

франц

герман

итали

япон

солонгос

португаль

орос

испани

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад зориулан зохицуулалт хийх нь

Суралцахуйн үнэлгээний шалгалтад онцгой тусламж үзүүлэх зорилго бол тусгай хэрэгцээ шаардлага, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл эрүүл мэндтэй холбоотой асуудал бүхий суралцагчдыг үнэлгээний шалгалтад бусад суралцагчтай ижил түвшинд оролцуулахад оршино. Багш нар суралцагчдынхаа тусгай хэрэгцээ шаардлага, хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндтэй холбоотой асуудлуудад нь зохих онцгой тусламж үзүүлсэн байх ёстой. Дараах зүйлс нь суралцагчдадаа онцгой тусламж үзүүлэхэд анхаарах удирдамж болно. Үүнд:

1. Тусгай хэрэгцээ эсвэл хөгжлийн бэрхшээлтэй байж болох суралцагчдыг олж тодорхойл. Тусгай хэрэгцээг нь олж тодорхойлохын тулд суралцагч бүртэй биечлэн ярилц. Анхааралтай сонсож, өөдрөг ханд. Та тэдний тусгай хэрэгцээний талаар илүү сайн ойлгохын тулд эцэг эх эсвэл Сүмийн удирдагчидтай нь уулзаж, ярилцаж болох юм.
2. Хийсэн ярилцлагууд дээрээ үндэслэн суралцагчийн тусгай хэрэгцээнд тохирсон тусламж үзүүлэх төлөвлөгөө гарга.
3. Зохицуулалт хий. Хувь хүмүүст үзүүлсэн тусламжийн талаарх мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах ёстой. Боломжтой бүх тусламжийг жагсаан бичих боломжгүй ч тодорхой хэдэн жишээг үзүүлэв. Үүнд:

Танилцуулга: Суралцагчид үнэлгээний шалгалтын аудио бичлэгийг өгөх, удирдамж ба үнэлгээний шалгалтыг амаар уншиж танилцуулах эсвэл суралцагчид үнэлгээний шалгалтын том үсгээр хэвлэсэн хувилбарыг өгөх (үнэлгээний шалгалтын боломжит форматуудыг Суралцахуйн үнэлгээний шалгалтын вэбсайт руу орж үзнэ үү).

Шалгалт өгөх орчин: Суралцагчийг ангид хүссэн газарт нь суулгах, анхаарал сарниулах зүйл хамгийн багатай хэсэгт орон зай гаргаж өгөх эсвэл үнэлгээний шалгалтыг жижиг бүлгээр юм уу өөр өрөөнд удирдан явуулах

Шалгалтын хуваарь: Үнэлгээний шалгалтыг хэсэгчлэн эсвэл хэд хэдэн өдөрт хуваан явуулах, шалгалтын хэсгүүдийг өөр өөр дарааллаар өгөх боломж олгох, шалгалт өгөх боломжтой цагт нь шалгалтыг авах, эсвэл шалгалтыг гүйцэтгэж дуусгах цагийг уртасгахыг зөвшөөрөх

Хариулт: Сонгосон хариултаа амаар өгөхийг мөн хариултаа өөр хүнд хэлж өгөх юм уу дуу хураагчид бичүүлэхийг зөвшөөрөх эсвэл хариултын хуудсан дээр биш, үнэлгээний шалгалтын номон дээр тэмдэглэхийг нь зөвшөөрөх

4. Суралцагчийн сурлагын түвшинг бууруулах эсвэл өөрчлөх зохицуулалт хийхээс зайлсхий.

5. Суралцагч бүрд Христийнхтэй адил хайрыг үзүүлж, тэдний хэрэгцээнд нийцүүлэн зохицуулалт хийхдээ Сүнсний өдөөлтийг дага.
6. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусламж үзүүлэх талаар илүү их ерөнхий мэдээлэл авахын тулд Сүмийн [lds.org/topics/disability](https://www.lds.org/topics/disability) вэбсайтыг руу орно уу.

Судлах удирдамж

Сургаал ба Гэрээ 1–75 ба Иосеф Смит—Түүх

Төгс эзэмших судрын асуултууд: Төгс эзэмших судрын хэсгүүдийн заадаг сургаалуудыг ойлгох.

- Иосеф Смит—Түүх 1:15–20
- Сургаал ба Гэрээ 1:37–38
- Сургаал ба Гэрээ 6:36
- Сургаал ба Гэрээ 8:2–3
- Сургаал ба Гэрээ 10:5
- Сургаал ба Гэрээ 13:1
- Сургаал ба Гэрээ 18:10–11
- Сургаал ба Гэрээ 18:15–16
- Сургаал ба Гэрээ 19:16–19
- Сургаал ба Гэрээ 19:23
- Сургаал ба Гэрээ 25:13
- Сургаал ба Гэрээ 46:33
- Сургаал ба Гэрээ 58:27
- Сургаал ба Гэрээ 58:42–43
- Сургаал ба Гэрээ 64:9–11

Нөхцөл байдлын талаарх асуултууд: Судрын тодорхой нэг хэсгийг тойрсон болон түүхэн нөхцөл байдлыг танилцуулсан томоохон үйл явдал эсвэл түүхийн заримыг ойлгох.

- Иосеф Смитийн ажил Бурханаас байсныг Оливер Каудери гэрчилсэн (С ба Г 6:22–23-ыг үзнэ үү)
- Гар бичмэлийн 116 хуудас алга болсон ба Иосеф Смитийн сурсан зарчмууд (С ба Г 3; 10-ыг үзнэ үү)
- Анхны үзэгдлээс сурсан үнэн (Иосеф Смит—Түүх 1:11–20-ийг үзнэ үү)
- Чухал үйл явдлуудын ерөнхий цаг хугацааны тоолол: Анхны үзэгдэл, Иосеф Смит алтан ялтсуудыг хүлээн авсан, санваарын сэргээлт, Сүмийн зохион байгуулалт ба Огайогийн Көртланд руу нүүсэн нь
- Аароны болон Мелкизедек санваарыг сэргээсэн тэнгэр элчүүд (С ба Г 13; Иосеф Смит—Түүх 1:72-ыг үзнэ үү)
- Сионы төв газар ба Сион гэдэг үгтэй холбоотой ойлголтууд (С ба Г 57; *Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт* [2004], 173-р хуудсыг үзнэ үү)

Сургаал, зарчмууд: Сургаал ба Гэрээнд заадаг үндсэн сургаал, зарчмуудыг ойлгох.

- Илчлэлтэд нөлөөлдөг зарчмууд: илчлэлт авахад бэлтгэх (С ба Г 9:7–9-ийг үзнэ үү), илчлэлтийг таних (С ба Г 8:1–5-ыг үзнэ үү), жинхэнэ илчлэлтийг хуурамч санаанаас ялган таних (С ба Г 50:10–36-г үзнэ үү), бошиглогч Сүмийг удирдах илчлэлтийг мөн дуудлагатай хүмүүс үүргээ биелүүлэхэд шаардлагатай илчлэлтийг хүлээн авдаг гэдгийг ойлгох нь (С ба Г 28:1–7-г үзнэ үү)
- Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм цорын ганц үнэн хийгээд амьд сүм болох шалтгаан (С ба Г 1:30; 18:1–5; 27:5–14; 33:1–6-г үзнэ үү)
- Сургаал ба Гэрээ Есүс Христийн Цагаатгал (С ба Г 29:30–45-ыг үзнэ үү), баптисм (С ба Г 20:72–74; 22:1–4-ийг үзнэ үү), ариун ёслол (С ба Г 20:77, 79; 27:1–2-ыг үзнэ үү), Сүнсний бэлгүүд (С ба Г 46:8–26-г үзнэ үү), гэрлэлт (С ба Г 49:15–17-г үзнэ үү), номлогчийн ажил (С ба Г 15:6; 33:7–10; 65:1–6-г үзнэ үү), Хоёр дахь ирэлтийн бэлтгэл (С ба Г 45:32, 39, 57-г үзнэ үү), судар (С ба Г 68:2–4-ийг үзнэ үү), өргөлийн хууль (С ба Г 42:30–42), Мормоны Ном (С ба Г 20:8–12-ыг үзнэ үү)-ын талаар юу заадаг талаар
- Сүүлийн эрин үед бошиглогч Иосеф Смитийн гүйцэтгэсэн үүрэг (С ба Г 27:5–14; 65:2-ыг үзнэ үү)
- Сүмийн өмнөөс илчлэлт хүлээн авах бошиглогчийн үүрэг (С ба Г 21:1, 4–6; 28:2, 6–7; 43:1–7-г үзнэ үү)

Үндсэн нэр томьёо: Үндсэн нэр томьёоны утга агуулгыг ойлгох

- Мөнх амьдрал (С ба Г 14:7; 20:17–28; 29:22–29; 66:4–13-ыг үзнэ үү)
- Үхэшгүй байдал (*Итгэлдээ үнэнч байх нь*, 52-р хуудсыг үзнэ үү)
- Шинэ ба үүрдийн гэрээ (С ба Г 66:2-ыг үзнэ үү)
- Их урвалт ба хувь хүний урвалт (*Итгэлдээ үнэнч байх нь*, 13–14-р хуудсыг үзнэ үү)
- Сүнслэг үхэл (С ба Г 29:40–41-ийг үзнэ үү)

Сургаал ба Гэрээ

76–Албан тунхаг 2

Төгс эзэмших судрын асуултууд: Төгс эзэмших судрын хэсгүүдэд заадаг сургаалыг ойлгох

- Сургаал ба Гэрээ 76:22–24
- Сургаал ба Гэрээ 76:40–41
- Сургаал ба Гэрээ 78:19
- Сургаал ба Гэрээ 82:10
- Сургаал ба Гэрээ 88:124
- Сургаал ба Гэрээ 89:18–21
- Сургаал ба Гэрээ 107:8
- Сургаал ба Гэрээ 121:36, 41–42
- Сургаал ба Гэрээ 130:22–23
- Сургаал ба Гэрээ 131:1–4

Нөхцөл байдлын талаарх асуултууд: Судрын тодорхой нэг хэсгийг тойрсон болон түүхэн нөхцөл байдлыг танилцуулсан зарим томоохон үйл явдал эсвэл түүхийг ойлгох

- Көртландын ариун сүмд бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёрт санваарын зарим түлхүүрийг сэргээсэн тэнгэр элчүүд (С ба Г 110:11–16-г үзнэ үү)
- Бошиглогч Иосеф Смитийн Либертигийн шоронд байхдаа сурсан сорилт бэрхшээлийн талаарх зарчмууд (С ба Г 122:7-г үзнэ үү)
- Эртний гэгээнтнүүдийн цугларсан томоохон газрууд (С ба Г 124, хэсгийн оршил; С ба Г 136, хэсгийн оршил, 1–18; *Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхийг гэрээр судлах семинарын суралцагчдын удирдамж* [2013], 339–349)
- Халамжийн Нийгэмлэгийн үүсгэн байгуулагдсан нь (*Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* [2011], 11–25-ыг үзнэ үү)
- Агуу Үнэт Сувд ном гарч ирсэн нь (*Doctrine and Covenants and Church History Study Guide*, 354–358)

Сургаал, зарчмууд: Сургаал ба Гэрээнд заадаг үндсэн сургаал, зарчмуудыг ойлгох

- Санваарын тангараг ба гэрээ (С ба Г 84:33–44-ийг үзнэ үү), амилуулалт ба алдар суугийн хаант улсууд (С ба Г 88:14–24-ийг үзнэ үү), Мэргэн ухааны үг (С ба Г 89-ийг үзнэ үү), Христийн гэрэл (С ба Г 88:1–13-ыг үзнэ үү), цамхгийн харуулууд (С ба Г 101:43–62-ыг үзнэ үү), Сүмийн сахилгын хурлууд (С ба Г 102; *Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт* [2004], 185-р хуудсыг үзнэ үү), олон эхнэртэй байх ёсыг зөвтгөсөн нь (С ба Г

132:45, 48-ыг үзнэ үү), дуулгавартай байдал (С ба Г 130:21-ийг үзнэ үү), аравны нэг (С ба Г 119-ийг үзнэ үү)

- Ариун сүмийн ажил (С ба Г 109; 110-ыг үзнэ үү), өвөг дээдсийнхээ өмнөөс ёслолуудыг хийж гүйцэтгэх нь (С ба Г 128:15-ыг үзнэ үү), сүнсний дэлхийд сайн мэдээг номлох нь (С ба Г 138:29–32-ыг үзнэ үү)
- Алдар суугийн хаант улсыг хүлээн авах ба селестиел хаант улсад өргөмжлөл хүртэх нь (С ба Г 76:30–70; 131:1–4; 137:10-ыг үзнэ үү)
- “Гэр бүл: Дэлхий дахинаа өргөх тунхаг”-г заасан үнэн (*Doctrine and Covenants and Church History Study Guide*, 373–376)
- Үнэн, ёслолууд ба санваарыг сэргээхэд бошиглогч Иосеф Смитийн гүйцэтгэсэн үүрэг (С ба Г 135:3-ыг үзнэ үү)
- Албан Тунхаг 2 дээр тунхаглан зарласан илчлэлт
- Бошиглогч нас барахад Тэргүүн Зөвлөл залгамжлах тухай (*Doctrine and Covenants and Church History Study Guide*, 334–339-ийг үзнэ үү)
- Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ (С ба Г 132:19–21-ийг үзнэ үү)

Үндсэн нэр томьёо: Үндсэн нэр томьёоны утгыг ойлгох

- Ариун сүмд хувийн хишгээ хүртэх нь (С ба Г 95:8; 109:22–23-ыг үзнэ үү)

Хуучин Гэрээ: Эхлэл–Рут

Төгс эзэмших судрын асуултууд: Төгс эзэмших судрын хэсгүүдэд заадаг сургаалуудыг ойлгох

- Мосе 1:39
- Мосе 7:18
- Абрахам 3:22–23
- Эхлэл 1:26–27
- Эхлэл 2:24
- Эхлэл 39:9
- Египетээс гарсан нь 19:5–6
- Египетээс гарсан нь 20:3–17
- Иошуа 24:15

Агуулгагай холбоотой асуултууд: Зарим гол түүх, хувь хүн, цаг хугацаа, бэлгэдлийг ойлгох

- Хуучин Гэрээний хамгийн чухал захиасууд мөн уг ном дээрх бэлгэдэл, хууль, дүрс, бошиглол, үйл явдлууд юуны тухай өгүүлж, юуг төлөөлдөг талаар (Мосе 5:7–8; Мозая 3:13–15-ыг үзнэ үү)
- Хаалганы тотгон дээрх цус (Египетээс гарсан нь 12:21–23-ыг үзнэ үү), хүрэл могой (Тооллого 21:8–9; Алма 33:19–22-ыг үзнэ үү) болон Абрахамаас Исаакийг тахил болгон өргөхийг хүссэн бэлгэдлүүд (Эхлэл 22:10–12; Иохан 3:16-г үзнэ үү)
- Мосе Сатаныг ялан дийлэхэд тусалсан ямар зүйлийг мэдэж байсан талаар (Мосе 1:4–7, 13-ыг үзнэ үү)
- Едений цэцэрлэгт Адам, Ева хоёрт өгсөн зарлигууд (Мосе 2:26–30; 3:16–17-г үзнэ үү)
- Ноа ба үер: Үер нь төрөөгүй байсан сүнснүүдэд болон тухайн цагт амьдарч байсан ёс бусчуудад хэрхэн адислал байсан талаар (Мосе 8:22–30; 2 Нифай 26:24; *Old Testament Study Guide for Home-Study Seminary Students* [2015], 38-ыг үзнэ үү)
- Иаков ба Есав: Есавын хийсэн сонголтууд нь ууган хүү байх эрхээ үл тоомсорлож байсныг харуулдаг (Эхлэл 25:29–34; 26:34–35; *Old Testament Study Guide*, 65–66-г үзнэ үү)
- Иосеф Египет рүү худалдагдсан: зовлон зүдгүүрийн талаар сурч мэдсэн зүйлс (Эхлэл 45:7–8; 50:20–21-ийг үзнэ үү)
- Мосе Израилийг чөлөөлөхийг хүссэн: Бурхан эргэлзээгээ арилгахад нь тусалсан ямар зүйлийг Мосед хэлсэн бэ (Египетээс гарсан нь 3:12, 17-г үзнэ үү)

- Цөл дэх Израилиас сурч мэдсэн зүйлс: Их Эзэн Өөрийгөө өдөр бүр израильчуудад сануулахын тулд тэдэнд юу өгсөн бэ? (Египетээс гарсан нь 16:4–5-ыг үзнэ үү), асрын адислалууд (Египетээс гарсан нь 25:8, 22; 29:43–46), Левит номонд дүрсэлсэн тахилууд Израилийг Есүс Христ рүү хандуулсан (Левит 1:3–9; 4:20–31; 16:21–22-ыг үзнэ үү), Калев, Иошуа хоёр “муу мэдээнд” хариулсан (Тооллого 14:7–9-ийг үзнэ үү)
- Амлагдсан нутаг руу орж, Иерихог эзэлсэн үйл явдлаас сурч мэдсэн зүйлс (Иошуа 6-г үзнэ үү)
- Гол бошиглогчдын ерөнхий цаг хугацааны тоолол: Адам, Енох, Ноа, Абрахам болон Моце (“Bible Chronology” in the Bible appendix; мөн LDS.org-ыг үзнэ үү)
- Хуучин Гэрээний эхний хэсэгт гардаг гол хүмүүс: Адам, Ева, Моце, Енох, Ноа, Абрахам, Лот, Сара, Исаак, Ребека, Иаков, Рахел, Есав, Иосеф, Аарон, Калев, Иошуа, Балаам, Самсон, Гидеон ба Рут

Сургаал, зарчмууд: Хуучин Гэрээнд заадаг үндсэн сургаал, зарчмуудыг ойлгох

- Бүтээлтэд Есүс Христийн гүйцэтгэсэн үүрэг (Моце 1:32–33-ыг үзнэ үү)
- Уналттай холбоотой зарчмууд: Уналтыг ялан дийлэхийн тулд мөнх бус амьдралын өмнөх дэлхийд юу хийсэн бэ? (Моце 4:2-ыг үзнэ үү) Уналтын дараах нөхцөл байдал (Моце 3:17; 4:11; 5:2; 6:48; 2 Нифай 2:22–23-ыг үзнэ үү), Уналт болсны дараа Адам, Ева хоёр Уналтын талаар юу мэдэж авсан бэ? (Моце 5:9–11-ийг үзнэ үү)
- Дахин төрөхтэй холбоотой сургаалууд (Моце 6:59), Абрахамын гэрээ (Абрахам 1:19; 2:6–11; Эхлэл 17:1–7-г үзнэ үү) болон чин сэтгэлийн наманчлал (*Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт* [2004], 133–137-ыг үзнэ үү)
- Енох Бурхан, Сатан хоёрын мөн чанарын талаар юу олж мэдсэн тухай (Моце 7:26–30-ыг үзнэ үү)
- Хуучин Гэрээнээс гэр бүл, гэрлэлтийн талаар сурч мэдсэн зүйлс: эрэгтэй, эмэгтэй хүний хоорондын гэрлэлт яагаад Бурханаас заяагддаг вэ? (Моце 3:18–25-ыг үзнэ үү) Ариун сүмийн гэрээнүүддээ үнэнч байсан хүмүүст зориулсан адислал (Эхлэл 28:1–22; *Old Testament Study Guide*, 67–69-ийг үзнэ үү), эхнэр, нөхрийн хоорондын харилцаа (Моце 3:18–25; Эхлэл 2:24-ийг үзнэ үү), гэрлэсэн хүмүүст өгсөн Бурханы зарлигууд (Моце 2:26–28-ыг үзнэ үү), эцэг эхчүүдэд өгсөн Бурханы зарлигууд (Моце 6:1, 5–6, 23-ыг үзнэ үү)

Үндсэн нэр томьёо: Үндсэн нэр томьёоны утгыг ойлгох

- Сонгогдсон үзмэрч (Иосеф Смитийн Орчуулга, Эхлэл 50:26–27 [Bible appendix]; 2 Нифай 3:6–7-г үзнэ үү)

Хуучин Гэрээ: 1

Самуел–Малахи

Төгс эзэмших судрын асуултууд: Төгс эзэмших судрын хэсгүүдийн заадаг сургаалуудыг ойлгох

- 1 Самуел 16:7
- Дуулал 24: 3–4
- Дуулал 119:105
- Дуулал 127:3
- Сургаалт Үгс 3: 5–6
- Исаиа 1:18
- Исаиа 5:20
- Исаиа 29:13–14
- Исаиа 53:3–5
- Исаиа 58:6–7
- Исаиа 58:13–14
- Иеремиа 1: 4–5
- Езекиел 37:15–17
- Амос 3:7
- Малахи 3:8–10
- Малахи 4:5–6

Агуулга, нөхцөл байдлын талаарх асуултууд: Зарим гол түүх, холбогдох зарчмыг ойлгох

- Самуел ба Ели: Самуелд тохиолдсон зүйл Их Эзэний дуу хоолойг таньж сурах талаар юу зааж байна вэ? (1 Самуел 3:4–10-ыг үзнэ үү)
- Израильчууд хаантай болохыг хүссэн шалтгаан (1 Самуел 8:6–7, 19–20-ийг үзнэ үү)
- Давид ба Голиат: Давид Голиатыг ялахын тулд юунд найдсан бэ? (1 Самуел 17: 37, 45–47-г үзнэ үү)
- Уzza гэрээний авдрыг түшсэн нь: эрх мэдэлгүй байж Бурханы ажлыг чиглүүлэх эсвэл залруулах талаар сурч мэдсэн зүйлс (2 Самуел 6:3–7-г үзнэ үү)
- Давид ба Батшеба: уруу татагдахаас зайлсхийж, тачаангуй хүслээ хянах талаар сурч мэдсэн зүйл (2 Самуел 11:1–5-ыг үзнэ үү)
- Соломон харь орны эмэгтэйчүүдтэй гэрлэсэн: Гэрээнээс гадуурх гэрлэлтийн үр дагавар (Хаадын дээд 11:3–6-г үзнэ үү)

- Елиа ба Зарифат дахь бэлэвсэн эмэгтэй: Бэлэвсэн эмэгтэйн итгэлээр үйлдэхийн тулд хийсэн зүйл (Хаадын дээд 17:9–16-г үзнэ үү)
- Елиа болон түүний Баалын эш үзүүлэгчидтэй хийсэн маргаан (Хаадын дээд 18:26–29, 36–39-ийг үзнэ үү)
- Нааман: Бошиглогчийг дагах талаар сурч мэдсэн зүйлс (Хаадын дэд 5:9–10, 13–14-ийг үзнэ үү)
- Иерусалимын ариун сүмийг сэргээн барьсан: (Езра 4:4–5; 5:1–5; 6:1–3, 7–8, 14-ийг үзнэ үү)
- Естер: Эр зоригийн талаар сурч мэдсэн зүйлс (Естер 3:6; 4:8, 11, 14; 5:1–2; 7:3–6-г үзнэ үү)
- Иов: Зовлон зүдгүүрийн талаар сурч мэдсэн зүйлс (Иов 13:13–16-г үзнэ үү)
- Даниел: Хааны ордон дахь туршлагаасаа олж мэдсэн үнэнүүд (Даниел 1:3–20-ийг үзнэ үү)
- Небухаднезар хааны зүүд: Бурханы хаант улсын талаарх үнэнүүд (Даниел 2:34–35, 44–45; С ба Г 65:2-ыг үзнэ үү)
- Шадрах, Мешах, Абед-него нар: Итгэлийн талаарх үнэнүүд (Даниел 3:14–18-ыг үзнэ үү)

Сургаал, зарчмууд: Хуучин Гэрээний заадаг үндсэн сургаал, зарчмуудыг ойлгох

- Ариун сүмд шүтэн биширснээр ирэх адислал (Хаадын дээд 8:37–40-ийг үзнэ үү; мөн Bible Dictionary, “Temple”-ийг үзнэ үү) мөн Сион уулан дээрх аврагчид болох нь (Обадиа 1:17, 21; *Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалууд: Иосеф Смит* [2007], 473-ыг үзнэ үү)
- Мянган жилийн нөхцөл байдал (Исаиа 65:21–25-ыг үзнэ үү)
- Есүс Христийн Цагаатгал: Хуучин Гэрээ нь бэлгэдэл, түүх, бошиглогчид болон төгс эзэмших судруудаар дамжуулан Есүс Христийг хэрхэн гэрчилдэг талаар (Моше 6:63-ыг үзнэ үү; мөн Мозая 3:15-ыг үзнэ үү)

Судрын гол үг хэллэгүүд: Судрын гол үг хэллэгүүдийн утга учир, ач холбогдлыг ойлгох

- “Би алгандаа чамайг сийлсэн” (Исаиа 49:16)
- “Би Өөрийн Сүнсийг бүх хүн төрөлхтөнд цутгана” (Иоел 2:28)

Шинэ Гэрээ: Матай–Иохан

Төгс эзэмших сургаалын асуултууд: Төгс эзэмших сургаалын хэсгүүдэд заадаг сургаалуудыг ойлгох

- Матай 5:14–16
- Матай 11:28–30
- Матай 16:15–19
- Матай 22:36–39
- Лук 24:36–39
- Иохан 3:5
- Иохан 7:17
- Иохан 14:15
- Иохан 15:16
- Иохан 17:3

Агуулга, нөхцөл байдлын талаарх асуултууд: Зарим гол түүх, холбогдох зарчмыг ойлгох

- Есүс баптисм хүртсэн: Бурхан Тэргүүтэний тухай мэдэж авсан үнэн (Матай 3:16–17-г үзнэ үү).
- Есүс соригдсон: уруу таталтыг давж гарах талаар сурч мэдсэн зүйлс (Матай 4:3–11-ийг үзнэ үү).
- Есүс Арванхоёр төлөөлөгчөө дуудсан: Төлөөлөгчид дуудагдсаныхаа дараа юу хүлээн авсан талаар (Матай 10:1–4-ийг үзнэ үү).
- Петр усан дээгүүр алхсан: айдас, эргэлзээгээ ялан дийлэх тухай сурч мэдсэн зүйлс (Матай 14:28–31-ийг үзнэ үү).
- Гараа угааж ариутгах уламжлал: биднийг бузарладаг зүйлсийн талаар өгсөн Есүсийн сургамж (Матай 15:10–20-ийг үзнэ үү)
- Петрийн гэрчлэл: гэрчлэл хүлээн авах тухай сурч мэдсэн зүйлс (Матай 16:13–19-ийг үзнэ үү)
- Гэрлэлтийн талаарх Их Эзэний сургаал: гэрлэлтийн тухай сурч мэдсэн зүйлс (Матай 19:3–9-ийг үзнэ үү)
- Аврагчийн амилсныхаа дараа төлөөлөгчдөд өгсөн зааварчилгаа (Матай 28:19–20-ийг үзнэ үү).
- Есүс баян залууд зөвлөгөө өгсөн: мөнх амьдралыг авахад бидэнд туслах үнэн (Матай 10:17–22-ыг үзнэ үү).
- Есүс Христийн замыг бэлтгэхээр илгээгдсэн элч хэн байсныг олж мэдэх (Лук 7:27–28-ыг үзнэ үү).
- Сайн самари хүний тухай сургаалт зүйрлэл: мөнх амьдралыг олоход бидэнд туслах үнэн (Лук 10:25–37-г үзнэ үү).

- Алдагдсан хонь, алдагдсан зоос ба үрэлгэн хүүгийн тухай сургаалт зүйрлэл: алдагдсан хүмүүст хэрхэн туслах талаар сурч мэдсэн зүйлс (Лук 15-ыг үзнэ үү).
- Аврагч Никодемд сүнсээр дахин төрөхийн тулд юу хийх ёстой талаар заасан (Матай 3:3–5-ыг үзнэ үү).
- Хуучин Гэрээний Бурхан Иехова хэн болохыг мэдэх (Иохан 8:56–58; Иохан 8:58, зүүлт тайлбар б-г үзнэ үү).
- Есүс Христийг хоньчинтой зүйрлэсэн бэлгэдлийг ойлгох нь (Иохан 10:11–15-ыг үзнэ үү).
- Есүс төлөөлөгчдийн хөлийг угаасан: үйлчлэлийн талаар сурч мэдсэн зүйлс (Иохан 13:12–17-г үзнэ үү).
- Бид Аврагчийг хайрладаг гэдгээ хэрхэн харуулж болох (Иохан 14:15-ыг үзнэ үү)
- Ариун Сүнсний үүрэг (Иохан 16:13; мөн Иохан 14:26-г үзнэ үү)
- Мөнх амьдрал олж авахад нэн чухал хэмээн Аврагчийн заасан зүйл (Иохан 17:3-ыг үзнэ үү)
- Аврагч үхлийг ялан дийлэхийн тулд юу хийсэн талаар (Иохан 20:17–20; мөн Иохан 5:26-г үзнэ үү)

Сургаал, зарчмууд: Хуучин Гэрээнд заадаг гол сургаал, зарчмуудыг ойлгох

- Есүс Христийн сургаал, зарлигуудыг дагах нь биднийг Тэнгэр дэх Эцэгтэйгээ илүү адил болоход тусалдаг (Матай 5:48-ыг үзнэ үү).
- Их Эзэний Хоёр дахь ирэлтэд бэлтгэх нь (Иосеф Смит—Матай 1:38–54-ийг үзнэ үү)
- Ариун ёслолоос хүртэх шалтгаан (Матай 26:26–28; Иосеф Смитийн Орчуулга 26:22, 24–25 [Bible appendix эсвэл Судруудын удирдамж, scriptures.lds.org]-ыг үзнэ үү)
- Хүндэтгэлийн өдрийн зорилго (Марк 2:23–3:6-г үзнэ үү)
- Есүс Христийн заасан сургаалын талаар хэрхэн гэрчлэлтэй болох (Иохан 7:16–18-ыг үзнэ үү)
- Авралын төлөвлөгөөн дэх Есүс Христийн үүргийн талаар мөн Түүний Цагаатгал хийх цорын ганц хүн байсан шалтгааныг тайлбарлахад бэлэн байх
- Есүс Христийн Цагаатгалын хэрэгцээ, үр дүнг тайлбарлахад бэлэн байх
- Есүс Христэд улам бүр ойртоход тусалсан сурч мэдсэн үнэнээ хуваалцахад бэлэн байх
- Энэ хичээлийн жилд Есүс Христэд илүү их ойртохын тулд хийж байгаа зүйлээсээ жишээ болгон хуваалцахад бэлэн байх

Судрын гол үг хэллэгүүд: Судрын гол үг хэллэгүүдийн утга учир, ач холбогдлыг ойлгох

- Аврагчийн Гетсемани дахь зовлон шаналлыг тайлбарладаг судрын зарим гол үг хэллэгийг ойлгох (Матай 26:38–39; Марк 14:32–34-ийг үзнэ үү)

Шинэ Гэрээ: Үйлс–Илчлэлт

Төгс эзэмших сургаалын асуултууд: Төгс эзэмших сургаалын хэсгүүдэд заадаг сургаалыг ойлгох

- Үйлс 3:19–21
- 1 Коринт 2:5, 9–11
- 1 Коринт 6:19–20
- 1 Коринт 11:11
- 1 Коринт 15:20–22
- 1 Коринт 15:40–42
- Ефес 2:19–20
- Ефес 4:11–14
- 2 Тесалоник 2:1–3
- 2 Тимот 3:15–17
- Еврей 12:9
- Иаков 1:5–6
- Иаков 2:17–18
- 1 Петр 4:6
- Илчлэлт 20:12

Агуулга, нөхцөл байдлын талаарх асуултууд: зарим гол түүх, холбогдох зарчмуудыг ойлгох

- Төлөөлөгч Петр Корнелд сайн мэдээг зааж байгаа нь: Бурханаас хүлээн авсан үнэнүүдийн тухай сурч мэдсэн зүйлс (Үйлс 10:28–35, 44–48-ыг үзнэ үү)
- Төлөөлөгч Паул Агрийп хаанд зааж байгаа нь: Есүс Христэд хөрвөгдөхөд юу хэрэгтэй талаар (Үйлс 26:26–29-ийг үзнэ үү)
- Баптисм юуны бэлгэ тэмдэг болох талаар (Ром 6:3–6-г үзнэ үү)
- Төлөөлөгч Паулын бидний бие махбодын тухай заасан зүйлс (1 Коринт 6:19–20-ийг үзнэ үү), эхнэр, нөхрийн хоорондын харилцаа (1 Коринт 11:11-ийг үзнэ үү), бидний өдрүүдэд байгаа аюулыг давж гарахад бидэнд юу тус болох (2 Тимот 3:15–17-г үзнэ үү), сорилт бэрхшээлийг давж гарах нь (Еврей 12:2–4-ийг үзнэ үү)
- Сүнсний үр жимсний жишээ (Галат 5:22–23-ыг үзнэ үү)
- Ач ивээл, ажил үйлсийн тухай үнэнүүд (Ефес 2:7–10; Иаков 2:17–18-ыг үзнэ үү)

- Бошиглогч, төлөөлөгчдийн үүрэг (Ефес 4:11–14-ийг үзнэ үү)
- Бурханы бүрэн хуяг дуулгыг өмссөнөөр ирэх адислал (Ефес 6:11–13-ыг үзнэ үү)
- Хуучин Гэрээний бошиглогчид гайхамшгийг хэрхэн үйлдсэн тухай (Еврей 11-ийг үзнэ үү)
- Мөнх бус байдлын өмнөх амьдралд зөв шударга хүмүүст Сатаныг ялан дийлэхэд тусалсан үнэнүүд (Илчлэлт 12:11-ийг үзнэ үү)

Сургаал, зарчмууд: Шинэ Гэрээн дээр заадаг үндсэн сургаал, зарчмуудыг ойлгох

- Бошиглогчид сайн мэдээний Сэргээлтийн тухай хэзээнээс бошиглож эхэлсэн талаар (Үйлс 3:21-ийг үзнэ үү)
- Бид Бурханы үр удам гэдгийг ойлгосноос ирэх адислал (Үйлс 17:28-ыг үзнэ үү)
- Баптисмын ёслолыг бүрэн гүйцэд болгоход юу шаардлагатай болох (Үйлс 19:2–6-г үзнэ үү)
- Нүглээсээ салж, зөвтгөгдөхөд юу шаардлагатай болох (Ром 3:24–26; Моронай 10:32–33-ыг үзнэ үү)
- Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхэд байснаар ирэх адислал (Ром 8:16–18-ыг үзнэ үү)
- Бурханы зүйлсийг хэрхэн ойлгох (1 Коринт 2:10–11, 14-ийг үзнэ үү)
- Есүс Христийн Амилалтаар юу боломжтой болсон талаар (1 Коринт 15:20–22-ыг үзнэ үү)
- Цаг хугацааны бүрэн байдлын эрин үеийн талаарх ойлголт (Ефес 1:10-ыг үзнэ үү)
- Хэн Тэнгэрлэг Эцэгийн сүнсэн хүүхдүүдийн ууган нь, бүх зүйлийн Бүтээгч, Сүмийн тэргүүн, хамгийн анх амилсан нь вэ? (Колоссай 1:12–19-ийг үзнэ үү)
- Есүс Христийн Хоёр дахь ирэлтэд бэлтгэх тухай үнэнүүд (1 Тесалоник 5:1–6-г үзнэ үү)
- Есүс Христийн тухай үнэнүүд: Түүний үүрэг, зан чанар (Еврей 1:1–3-ыг үзнэ үү)
- Санваар хүлээн авсан хүмүүсийг удирдах үнэнүүд (Еврей 5:4-ийг үзнэ үү)
- Бид мэргэн ухаанаар дутах үедээ юу хийж болох талаар (Иаков 1:5–6-г үзнэ үү)
- Нас барагсдын авралын тухай сургаалууд: Нас барсан хүмүүст сайн мэдээг номлодог шалтгаан (1 Петр 4:6-г үзнэ үү)

Судрын гол үг хэллэгүүд: Судрын гол үг хэллэгүүдийн утга учир, ач холбогдлыг ойлгох

- “Бурханлаг харуусал” (2 Коринт 7:10; *Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт* [2004], 136-г үзнэ үү)

- “Бүхнийг сэргээх үе” (Үйлс 3:21; Үйлс 3:19–21-ийг үзнэ үү)
- “Цаг хугацааны бүрэн байдлын эрин үе” (Ефес 1:10; С ба Г 128:18; Bible Dictionary, “Dispensations”)-ыг үзнэ үү.

Мормоны Ном: 1 Нифай

1–Алма 16

Төгс эзэмших сургаалын асуултууд: Төгс эзэмших сургаалын хэсгүүдэд заасан сургаалыг ойлгох

- 1 Нифай 3:7
- 2 Нифай 2:22–25
- 2 Нифай 2:27
- 2 Нифай 26:33
- 2 Нифай 28:30
- 2 Нифай 32:3
- 2 Нифай 32:8–9
- Мозая 2:17
- Мозая 2:41
- Мозая 3:19
- Мозая 4:9
- Мозая 18:8–10
- Алма 7:11–13

Агуулга, нөхцөл байдлын талаарх асуултууд: Зарим гол түүх, холбогдох зарчмыг ойлгох

- Мормоны Номын бурханлаг чанарын талаарх ямар гэрчлэл хэн нэгэнд үүнийг олж мэдэхэд тус болох вэ? (Мормоны Номын удиртгал, 8–9 дэх догол мөрийг үзнэ үү)
- Мормоны Номын зохиогчдын гол санаа (1 Нифай 6:4–6; 2 Нифай 25:23-ыг үзнэ үү)
- Нифай гуулин ялтсуудыг олж авсан нь: дуулгавартай байдлын талаар сурч мэдсэн зүйлс (1 Нифай 3:7-г үзнэ үү)
- Лихайн хөвгүүд Ишмэйлийн гэр бүлийнхэнтэй хамт эргэн ирэв: гэрлэлтийн талаар сурч мэдсэн зүйлс (1 Нифай 7:1–5-ыг үзнэ үү)
- Нифай бага ялтсуудыг бүтээв: зарлигуудыг дагах талаар сурч мэдсэн зүйлс (1 Нифай 9:3, 5–6; С ба Г 10:38–45-ыг үзнэ үү)
- Мормоны Ном бүх хүнд ямар боломж олгодог тухай (1 Нифай 13:26–29, 39–42-ыг үзнэ үү)
- Лиахона: Бурханаас удирдамж хүлээн авах талаар сурч мэдсэн зүйлс (1 Нифай 16:27–29-ийг үзнэ үү)
- Мормоны Ном бошиглогч Иосеф Смитийн талаар юу заадаг вэ? (2 Нифай 3:6–8, 15, 24-ийг үзнэ үү)

- Эцсийн өдрүүдэд зарим хүн бошиглогчдод хэрхэн хандах талаарх бошиглолууд (2 Нифай 27:1–5-ыг үзнэ үү)
- Мормоны Номыг Иосеф Смит хэрхэн орчуулах талаарх бошиглол (2 Нифай 27:6–23-ыг үзнэ үү)
- Ариун явдлын талаарх Их Эзэний бодол (Иаков 2:22–35-ыг үзнэ үү)
- Зарлигуудыг дагаснаар хүлээн авах адислалуудын тухай хаан Бенжаминь сургаалууд (Мозая 2:41-ийг үзнэ үү)
- Эгэл хүнээ орхисны үр дүн (Мозая 3:19-ийг үзнэ үү)
- Үзмэрч юу мэддэг талаар (Мозая 8:13–17-г үзнэ үү)
- Леменчүүд нифайчуудыг үзэн ядсан нь: өршөөлийн талаар сурч мэдсэн зүйлс (Мозая 10:12–18-ыг үзнэ үү)
- Алма ба түүний хүмүүсийн боолчлол: сорилт бэрхшээлийн талаар сурч мэдсэн зүйлс (Мозая 23:20–24; 24:16–21-ийг үзнэ үү)
- Мелкизедек санваартнуудын үндсэн үүрэг (Алма 13:1–12-ыг үзнэ үү)

Сургаал, зарчмууд: Мормоны Номонд заадаг үндсэн сургаал, зарчмуудыг ойлгох

- Ёс суртахууны сонгох эрх гэж юу болох, энэ нь авралын төлөвлөгөөтэй хэрхэн уялддаг талаар (2 Нифай 2:5, 14–16, 27–29-ийг үзнэ үү)
- Авралын төлөвлөгөөн дэх Есүс Христийн үүрэг (2 Нифай 25:19–20-ийг үзнэ үү).
- Тэнгэрлэг Эцэгийн мөн чанар (2 Нифай 26:33-ыг үзнэ үү)
- Асуулт болон залбирлынхаа хариултыг хүлээн авахтай холбоотой зарчмууд (2 Нифай 28:30-ийг үзнэ үү)
- Баптисм хүртэх шалтгаан (2 Нифай 31:5–7-г үзнэ үү)
- Үнэнийг эрэлхийлэхийн тулд хийвэл зохих үйлдлүүд (2 Нифай 32:3, 8–9-ийг үзнэ үү)
- Ариун явдал (Иаков 2:27, 30-ийг үзнэ үү) ба гэрлэлтийн (Иаков 2:22–35-ыг үзнэ үү) талаарх Их Эзэний бодол
- Бүх үнэний эх сурвалж (Мозая 4:9-ийг үзнэ үү)
- Баптисмын гэрээ (Мозая 18:9-ийг үзнэ үү)
- Есүс Христ Цагаатгалаар өөр дээрээ юу хүлээн авсан талаар (Алма 7:11–13-ыг үзнэ үү)
- Амилах гэдэг нь ямар утгатай болох (Алма 11:42–43-ыг үзнэ үү)
- *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ын Сүнслэг мэдлэг олж авах нь гэсэн хэсгийн 3 зарчмыг тайлбарлахад бэлэн байх
- Адам, Ева хоёрын уналт ба Есүс Христийн Цагаатгалыг тайлбарлахад бэлэн байх

- Мормоны Номыг судалснаар амьдралд тань нөлөөлсөн хүний эсвэл түүхийн талаар бичихэд бэлэн байх
- Амьдралын модны үзэгдлийг хураангуйлан, уг үзэгдлийн бэлгэдлүүдийг тайлбарлаж, аль нэг бэлгэдлээс сурсан зүйлээ хуваалцахад бэлэн байх

Мормоны Ном: Алма

17–Моронай 10

Төгс эзэмших сургаалын асуултууд: Төгс эзэмших судрын хэсгүүдийн заадаг сургаалыг ойлгох

- Алма 34:9-10
- Алма 39:9
- Алма 41:10
- Хиламан 5:12
- 3 Нифай 11:10-11
- 3 Нифай 12:48
- 3 Нифай 18:15, 20–21
- 3 Нифай 27:20
- Ифер 12:6
- Ифер 12:27
- Моронай 7:45, 47–48
- Моронай 10:4–5

Агуулга, нөхцөл байдлын талаарх асуултууд: Зарим гол түүх, холбогдох зарчмыг ойлгох

- Антай-Нифай-Лихайчууд: Их Эзэнд хөрвөгдөх талаар сурч мэдсэн зүйлс (Алма 23:5–13-ыг үзнэ үү)
- Алма үгийг үртэй харьцуулсан нь: итгэлээ хүчирхэгжүүлэх талаар мэдэж авсан сургамж ба үе шатууд (Алма 32-ыг үзнэ үү)
- Есүс Христийн Цагаатгалын мөн чанар (Алма 34:9–10-ыг үзнэ үү)
- Бурханы зарлигуудыг дагаж сурах хамгийн тохиромжтой цаг (Алма 37:35-ыг үзнэ үү)
- Шударга ёсны шаардлагыг хангахад юу хэрэгтэй талаар (Алма 42:15–31-ийг үзнэ үү)
- Залуу дайчид: дуулгавартай байдлын талаар сурч мэдсэн зүйлс (Алма 57:21-ийг үзнэ үү)
- Бардамнал ба устгалын мөчлөгөөс мултарч гарах шийдэл (Хиламан 11-ийг үзнэ үү)
- Христийн төрөлтийн бошиглолууд биелснээс сурч мэдсэн зүйлс (3 Нифай 1:1–26-г үзнэ үү)
- Есүс Христ Тэнгэрлэг Эцэгийн хүслийг хэр дагадаг талаар (3 Нифай 11:10–11-ийг үзнэ үү)

- Биднийг ямар бай хэмээн зарлигласан тухай (3 Нифай 12:48-ийг үзнэ үү)
- Мөнх амьдралыг олж авах арга зам (3 Нифай 27:16-г үзнэ үү)
- Их Эзэний ариусгах урилга (3 Нифай 27:20-ийг үзнэ үү)
- Бидний сул дорой байдлын талаарх Их Эзэний амлалтууд (Ифер 12:27-г үзнэ үү)
- Сүмийн бусад гишүүний өмнө хүлээх бидний үүрэг (Моронай 6:4-ийг үзнэ үү)
- Энэрлийн бэлэг (Моронай 7:45, 47–48-ыг үзнэ үү)
- Мормоны Номын талаар гэрчлэлтэй болох загвар (Моронай 10:3–5-ыг үзнэ үү)
- Их Эзэн эцсийн өдрүүдэд Израилийг цуглуулна гэсэн амлалтаа биелүүлж байгаагийн нэг шинж тэмдэг (3 Нифай 21:1–11-ийг үзнэ үү).

Сургаал, зарчмууд: Мормоны Номонд заадаг үндсэн сургаал, зарчмуудыг ойлгох

- Үр удмаа үлдээх хүчийн ариун нандин мөн чанар (Алма 39:9-ийг үзнэ үү)
- Амилах гэдэг нь ямар утгатай болох (Алма 40:21–26-г үзнэ үү)
- Есүс Христ дээр сууриа тавих нь (Хиламан 5:12-ыг үзнэ үү)
- Яагаад бүх залбирал, адислал болон санваарын адислалыг Есүс Христийн нэрээр үйлдэх ёстой талаар (*Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ын сургаалын 1 дэх сэдэв болох “Бурхан Тэргүүтэн”-ий “Есүс Христ” хэсгийн гурав дахь догол мөрийг үзнэ үү; мөн 3 Нифай 18:15, 20–21; Моронай 7:28; С ба Г 45:3–5-ыг үзнэ үү)
- Их Эзэний гэрээт хүмүүсийн хувьд хүлээх бидний үүрэг (1 Нифай 22:9; 3 Нифай 20:27; Bible Dictionary, “Abraham, covenant of”; Абрахам 2:9–11-ийг үзнэ үү)
- Бидний амьдралд гайхамшиг тохиолдоход шаардлагатай зүйлс (Мормон 9:20-ийг үзнэ үү)
- Итгэл гэж юу болох талаар (Ифер 12:6-г үзнэ үү)
- Ариун Сүнсний бэлэг хүртээхэд ямар санваар шаардлагатай болох (Моронай 2:2, зүүлт тайлбар б; *Итгэлдээ үнэнч байх нь: Судрын заалт* [2004], 123)
- Санваарын алба хүлээн авахад шаардлагатай зүйлс (Моронай 3-ыг үзнэ үү)
- Ариун ёслолын залбирлаар амласан адислал (Моронай 4–5-ыг үзнэ үү)
- Наманчлалын амлалт ба адислал (Моронай 6:5–9-ийг үзнэ үү)
- Өөрт тулгарсан асуулт эсвэл асуудлаа шийдвэрлэхдээ *Төгс эзэмших сургаалыг судлах үндсэн материал*-ын “Сүнслэг мэдлэг олж авах нь” хэсгийн гурван зарчмын нэгийг хэрхэн хэрэгжүүлснээ хуваалцахад бэлэн байх
- Аврагчийн нифайчууд дээр айлчилсан айлчлалыг судалснаар мэдэж авсан зүйлсээ хуваалцахад бэлэн байх (3 Нифай 11–26-г үзнэ үү)

- Авралын төлөвлөгөөг тайлбарлахад бэлэн байх
- Мормоны Номыг судалснаар амьдралд тань нөлөөлсөн хүний эсвэл түүхийн талаар бичихэд бэлэн байх



ШАШНЫ ИНСТИТУТ
БА СЕМИНАР

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ